



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/4/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Б.Одхүү

Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	6
2.1. Оршил	6
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	6
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө	8
2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт	9
2.8.3 Авлага	9
2.8.4 Урьдчилгаа	9
2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт	9
2.8.6 БАРАА МАТЕРИАЛ	9
2.8.7 Үндсэн хөрөнгө	10
2.8.8 Өр төлбөр	10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо	11
2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3. Менежментийн захидал	14
3.1 ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ	14
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24



Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

 ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 21000, Дорнод аймаг, Хоргон сум 7-р баг ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7038-4203		ЧУЛУУНХОРООТ СУМЫН ЗАСАГ ДАРГА З.ГЭРЭЛТ-ОД ТАНАА	
2020.03.26 № 328			
танай	-ны №	-т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Чулуунхороот сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт			
Чулуунхороот сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл			
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.			
Аудитаар Чулуунхороот сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.			
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110520248			



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч З.Гэрэлт-Од танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын талаарх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Чулуунхороот сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одхүү хариуцаж гүйцэтгэв.

Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 0-ны өдрийн 1/73 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Чулуунхороот сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Чулуунхороот сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Чулуунхороот сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Чулуунхороот сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 16 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардал 2,027.6 сая төгрөгийн 2 хувь буюу 40.5 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 52.3 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 2 тусгай сангийн нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллага аудитад хамрагдсан.



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 6 байгууллагын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгч, 3 байгууллагын тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

- Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 15,272.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, сум хөгжлийн сан нь тайланд онд олгосон зээлийн 3 жилийн хүүг нийт дүнгээр авлагаар тусгасныг санхүүгийн тайланд залруулж, авлагыг 3,272.6 мянган төгрөгөөр бууруулж, алдааг аудитын явцад залруулж, 11,999.5 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

1. Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 8,0 сая төгрөгийн ЦДАШ-ын ажил хийгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2, 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

2. ИТХ нь нийт худалдан авалтын 31,5 хувь буюу 3,999.5 мянган төгрөгийн е-баримтыг анхан шатны баримт болгон хавсаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 6.5 дахь заалт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд сум хөгжүүлэх сангийн залруулгаас гадна өөр залруулга хийгдээгүй байна.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 106,430.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 125,025.3 мянган төгрөг болж, 18,594.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт (+), Бууралт (-)</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	106,430.6	125,025.3	+18,594.7	17,4
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Хадгаламж</u>				
<u>Дүн</u>	106,430.6	125,025.3	+18,594.7	17,4



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 125,025.3 мянган төгрөгөөс төрийн сангийн харилцах дансанд 122,861.7 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 2,163.6 мянган төгрөг байршиж байна.

2.8.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт хийгдээгүй байна.

2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 120,349.8 мянган, эцсийн үлдэгдэл 144,784.6 мянган төгрөг болж, 24,434.8 мянган төгрөгөөр өссөн байна.
Хүснэгт №3 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	8.0	00	8.0
Төлбөртэй үйлчилгээний авлага			
Татаас, санхүүжилтийн авлага			
Зээлийн хүүгийн авлага			
Бусад авлага	120,341.8	144,784.6	+24,442.8
Зээлийн авлага			
Дүн	120,349.8	144,784.6	24,434.8

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 94,763.1.6 мянган төгрөгийн авлага байна.
Авлагыг насжилтаар харуулбал Үүнд:

- Сум хөгжүүлэх сангийн 1 жилийн насжилттай 50,021.5 мянган төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 2-3 жилийн насжилттай 93,384.0 мянган төгрөгийн авлага
- Сум хөгжүүлэх сангийн 5-аас дээш жилийн насжилттай 1379.1 мянган төгрөгийн авлага байна.

Хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү болон алдангийг сумаас мэдэгдэх хуудас өгөх болон шүүхэд шилжүүлэх арга хэмжээ авч ажилласан байна.

Зээлийн төлбөрөө хугацаандаа төлөөгүйн улмаас дараа дараагийн зээлийн олголтод сөрөг үр дагавартай байна.

2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа данс үлдэгдэлгүй байна.

2.8.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. данс үлдэгдэлгүй байна.

2.8.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 334,902.2 мянган, эцсийн үлдэгдэл 368,408.0 мянган төгрөг болж, 33,505.8 мянган төгрөгөөр өссөн байна.

ДОА-2020/4/СТА-ТТЗ



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт №06 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	640.3	775.8	+135.5
Эм боох	0	0	
Дуусаагүй үйлдвэрлэл	0	0	
Бэлэн бүтээгдэхүүн	154.9	0	-154.9
Бичиг хэргийн материал	1232.3	0	-1,232.3
Аж ахуйн материал	158,762.7	186,142.6	+27,379.3
Сэлбэг хэрэгсэл	0	0	
Түлш, шатах тослох материал	2,451.1	2,890.4	
Барилгын засварын материал	0	0	
Хүнсний материал	628.2	803.2	
Бусад хангамжийн материал	7,774.8	8,703.1	
Биологийн хөрөнгө	0	0	
Мал амьтад	163,257.9	169,092.9	
Дүн	334,902.2	368,408.0	33,505.8

Тайлант онд бараа материал нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 264,159.6 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 463.7 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 43,061.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 463.7 мянган төгрөг, зарцуулсан 273,714.8 мянган төгрөгөөр хасагдсан байна. Мөн ашиглалтгүй, байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй бараа материал байхгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,893,520.2 мянган, эцсийн үлдэгдэл 3,243,875.1 мянган төгрөг болж, 649,645.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №07 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	1,993,584.1	2,048,194.1	+54,610.0
Тээврийн хэрэгсэл	256,544.8	86,765.2	-169,779.6
Машин тоног төхөөрөмж	377,045.8	245,435.7	-131,610.1
Тавилга эд хогшил	224,976.0	127,229.2	-97,746.8
Зам гүүрийн байгууламж	93,877.6	89,588.3	-4,289.3
Түүх соёлын дурсгалт зүйл	23,600.0	23,600.0	0.0
Дуусаагүй барилга байгууламж	46,000.0	16,000.0	-30,000.0
Номын фонд			
Бусад үндсэн хөрөнгө	15,162.9	15,329.4	+166.5
Программ хангамж	793,598.9	529,879.5	-263,719.4
Бусад биет бус хөрөнгө	11,078.0	3,801.6	-7,276.4
	58,052.0	58,052.0	0.0
Дүн	3,893,520.1	3,243,875.0	-649,645.1

Тайлант онд үндсэн хөрөнгө нь төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 34,718.6 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 9,531.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 296,537.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 30,000.0 мянган төгрөг, акталсан 37,985.1 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд дуусаагүй зуухны ажлын болон, сумын төлөвлөгөөний макетний 16,000.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийг бүртгэсэн байна.

2.8.8 Өр төлбөр



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 4,400.0 мянган төгрөг, жилийн эцэст үлдэгдэлгүй болж 4,400.0 мянган төгрөгөөр буурсан байна.
Хүснэгт №8 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өссөн+ Буурсан -</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Богино хугацаат өр төлбөр дүн</u>	4,400.0		-4,400.0	
<u>Урт хугацаат өр төлбөр дүн</u>				
<u>Нийт дүн</u>	4,400.0		-4,400.0	

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 3,731,666.1 мянган, эцсийн үлдэгдэл 3,882,093.1 мянган төгрөг болж 150,427.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь үндсэн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 9. ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО /МЯНГАН ТӨГРӨГ/

<u>Үзүүлэлт</u>	<u>Эхний үлдэгдэл</u>	<u>Эцсийн үлдэгдэл</u>	<u>Өсөлт/+/- бууралт</u>	<u>Дүнд эзлэх хувь</u>
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	1,556,746.5	1,556,746.5	0.0	
<u>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Өмч /хувийн/ /ТӨҮГ/</u>				
<u>Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/</u>				
<u>Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/</u>				
<u>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</u>				
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	496,431.9	652,938.1	156,506.2	
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	1,678,487.6	1,672,408.4	-6,079.2	
<u>Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү</u>				
<u>Бодлогын өөрчлөлт алдааны залруулга</u>				
<u>Дүн</u>	3,731,666.1	3,882,093.1	150,427.0	

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Font: Arial, Font color: Auto, Mongolian (Mongolia)

Formatted: Right, Space After: 0 pt

Засгийн газрын оруулсан капитал болон хөрөнгийн дахин үнэлгээний үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

/ Сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 01 дүгээр тогтоолд/ зааснаар тайлант онд 31,550.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

батлагдсанаас гүйцэтгэлээр 44,249.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 140.3 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1,500.0	1,605.6	105.6	107.0
Шууд бус орлого	15,000.0	26,848.2	11,848.2	178.9
Бууны албан татвар	1,050.0	1,050.0	0.0	100.0
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	2,353.4	353.4	117.6
Хадгаламжийн Хүүгийн орлого	9,000.0	9,881.1	881.1	109.8
Торгуулийн орлого	1,500.0	2,510.9	1,010.9	167.4
Бусад	1,500.0	0	-1500.0	0.0
Нийт дүн	31,550.0	44,249.2	12,699.2	140.3

Төсвийн орлого 12,699.2 мянган төгрөгөөр давсан нь үйл ажиллагааны орлого, шууд бус орлого, бууны албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, хадгаламжийн хүүгийн орлогууд давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 1,825,696.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,772,293.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 37,555.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,033,003.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 551,892.6 орон нутгийн төсвөөс, 18604.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,033,003.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 551,892.6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,604.8 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан бөгөөд Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт нь гүйцэтгэлээрээ олгогдсон байна.

Туслах үйл ажиллагааны орлого 539,3 мянган төгрөгөөр тасарсан нь ЗДТГ-т өөрийн орлого бүрдүүлэх үйл ажиллагаа хязгаарлагдмал байгаатай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,772,293.3 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь төвлөрүүлсэн санхүүжилт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 130,195.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 121,785.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төрийн сангийн дансанд 8,410.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт төсөвт дээд шатны төсвийн захирагчаас 60,568.6 мянган төгрөг, ЗДНХ-өөс 2,815.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,500.7 мянган төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 5,032.0 мянган төгрөг, норматив зардалд 1,080.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 614.8 мянган төгрөг, бусад зардалд 60,157.6 мянган төгрөг нийт 66,884.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумдын Засаг дарга нар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс, журамд зөвшөөрөгдөөгүй арга хэмжээнд зарцуулахаар захирамж гаргаж байгааг анхаарах шаардлагатай.



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.11. Шилэн дансны мэдээлэл

Чулуунхороот сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 122 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид тогтоосон, ОНХС-гаас анхан шатны баримттын бүрдэл хангаагүй олгосон 4,400.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт 100 хувь хэрэгжүүлсэн байна. Төсвийг батлахдаа сумын ИТХ-ын хурлын тогтоолд хөтөлбөрүүдийн хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тусгаж байх гэсэн албан шаардлага өгснийг хэрэгжүүлсэн байна.

Эдгээрийн хэрэгжилтийг 2019 оны 05 сарын 21-ний 1/351 тоотой хүргүүлж ажилласан байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Чулуунхороот сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦИЙН ХӨРӨНГӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

3.1.1 Илрүүлэлт: Төсвийн тухай хууль, Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг зөрчин Засаг даргын захирамжаар журамд заагдаагүй арга хэмжээнд зарцуулсан байна.

3.1.2 Эрсдэл: Хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтыг мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Чулуунхороот сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	561 682 768,56	638 218 021,96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	106 430 683,09	125 025 325,54
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	106 430 683,09	125 025 325,54
3121	Төгрөг	106 430 683,09	125 025 325,54
31211	Төрийн сангийн харилцах	98 672 116,19	122 861 713,64
31213	Арилжааны банк дахь харилцах	7 758 566,90	2 163 611,90
33	АВЛАГА	120 349 833,20	144 784 648,50
335	Бусад авлага	120 341 842,00	144 784 648,50
3351	Байгууллагаас авах авлага	12 592,00	21 499,50
3352	Хувь хүмүүсээс авах авлага	120 329 250,00	144 763 149,00
35	БАРАА МАТЕРИАЛ	334 902 252,27	368 408 047,92
351	Түүхий эд материал	640 338,00	775 858,00
35110	Тусгай зориулалттай материал	640 338,00	775 858,00
354	Хангамжийн материал	170 849 106,27	198 539 289,92
35420	Аж ахуйн материал	158 762 730,07	186 142 627,92
35440	Түлш, шатах тослох материал	2 451 122,00	2 890 384,00
35460	Хүнсний материал	628 223,00	803 161,00
35470	Бусад хангамжийн материал	7 774 775,50	8 703 117,00
35600	Мал амьтад	163 257 900,00	169 092 900,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3 174 383 334,02	3 243 875 058,51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3 174 383 334,02	3 243 875 058,51
392	Биет хөрөнгө	3 112 795 084,14	3 182 021 489,25
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 993 584 080,15	2 118 025 522,14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(69 831 374,14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	256 544 800,00	262 394 800,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(145 282 156,48)	(175 629 587,36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	377 045 818,20	471 815 245,20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(203 520 072,30)	(226 379 471,88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	224 975 999,51	250 175 823,19
39208	Хуримтлагдсан элэгдэл	(105 744 512,95)	(122 946 627,85)
39209	Зам, гүүрийн байгууламж	93 877 618,00	113 457 618,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(13 930 327,68)	(23 869 324,83)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	23 600 000,00	23 600 000,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	793 598 903,50	828 234 715,70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(243 117 975,81)	(298 355 258,92)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	46 000 000,00	16 000 000,00
39217	Ном	15 162 910,00	15 329 410,00
393	Биет бус хөрөнгө	61 588 249,88	61 853 569,26
39301	Програм хангамж	11 078 050,00	12 010 250,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7 541 800,12)	(8 208 680,74)
39303	Бусад биет бус хөрөнгө	58 052 000,00	58 052 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3 736 066 102,58	3 882 093 080,47
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3 731 666 102,58	3 882 093 080,47
51	Засгийн газрын хувь оролцоо	3 731 666 102,58	3 882 093 080,47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 556 746 536,54	1 556 746 536,54
512	Хуримтлагдсан үр дүн	496 431 935,95	652 938 153,96
51210	Өмнөх үеийн үр дүн	325 884 387,31	502 511 176,07
51220	Тайлант үеийн үр дүн	170 547 548,64	150 426 977,89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1 678 487 630,09	1 672 408 389,97
